**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 27 өдөр Дугаар А/1138 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 96 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг ажлын худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван)-т, шилжүүлэн, холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 110,000,000 (нэг зуун арван сая) төгрөгийг "Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын "24.1.2"-ын "III.1"-д заасан ""Цахим Улаанбаатар" төсөл"-ийн хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (Б.Даваанням)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

1110204885

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
09 дүгаар сарын 27-ны өдрийн
А/438 захирамжийн
хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨР ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

(сая төгрөг)

| | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | 2023 онд санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | | |
| 1 | Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан нэгдсэн санг бий болгох ажил | 2023 | 2023 | 110.0 | 110.0 |
| | | | | 110.0 | 110.0 |